



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 26 өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕЙН ТАМИР, ДИЗАЙН
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Бүрэн дунд боловсрол X-XII анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН УРАН
ЗОХИОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Бүрэн боловсролын X анги.
Заавал судлах ба сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар
2019

“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг, магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Багийн гишүүд

Монгол хэл

М.Базаррагчаа

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Мөнгөнцэцэг

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Оюунцэцэг

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Ц.Өнөрбаян

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

Ц.Туул

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

Б.Цасанчимэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга

зүйч

Ө.Цэндсүрэн

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Уран зохиол:

Г.Галбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн эрхлэгч

Ц.Март

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

П.Нармандах

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Одсүрэн

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Д.Туяа

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

С.Энхбаяр

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

Үндэсний бичиг:

Ү.Ариунболд

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Д.Баттогтох

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Б.Батчимэг

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Н.Мөнхцэцэг

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Хөндлөнгийн шинжээч

А.Цог-Очир

Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ц.Оюун

Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Б.Сүхболд

ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ш.Оюунцэцэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ: Х АНГИЙН УРАН ЗОХИОЛ (ЗААВАЛ СУДЛАХ)

Энэхүү бичиг баримт нь бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн дагуу 10 дугаар ангид уран зохиолын хичээлийн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, удирдаж чиглүүлэх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой зөвлөмж болно.

10 дугаар ангийн уран зохиолын хичээлийн агуулга нь монголын өөр өөр цаг үеийн уянга, туульс, жүжгийн зохиолоос шүлэглэсэн болон үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичсэн шилдэг зохиолоос уншиж, түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар сурагчид монголын уран зохиолын уламжлал, шинэчлэлийн талаар мэдлэг ойлголт эзэмшиж, шүүмжлэлт ба бүтээлт сэтгэлгээгээ хөгжүүлэхэд чиглэнэ.

Судлах эх зохиолууд нь монголын эртний болон орчин үеийн уран зохиолоос монголын түүх, соёл, нийгмийн онцлог байдлыг тусгасан, үндэсний ухамсар, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан утга сэдэвтэй, цагийн шалгарлыг давж үнэлэгдсэн шилдэг бүтээлүүд байна.

Арга зүйн хувьд эхлээд монголын эртний уран зохиолын дүрслэл, хүүрнэлийн сонгодог уламжлалаас төлөөлөх чанартай гол зохиолыг сонгож бүрэн эхээр уншин, тус зохиолын сэдэв, өгүүлэгдэхүүн, дүр, орчин, хэл найруулгын онцлогийг тодруулсны дараа орчин үеийн уран зохиолоос сэдэв, хам сэдвийн хувьд шууд холбогдох шилдэг зохиолоос сонгон уншиж, хоёр зохиолын сэдэв утгын адил ба ялгаатай талыг харьцуулан судална. Сурагчид нэгэн сэдвээр өөр өөр цаг үед бичсэн шилдэг бүтээлүүдийн сэдэв, хам сэдвийн хүрээнд хэлэлцэх замаар асуудлыг олон талаас харж шийдвэрлэх, өөр хоорондоо харилцан хэлэлцэж шийдвэр гаргах дадал хэвшлийг олох төдийгүй уран зохиолыг бие даан унших хүсэл, сонирхол, хэрэгцээ бий болж, унших зохиолдоо сонголттой ханддаг болно.

Суралцахуйн зорилтууд	Сургалтын үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.1а Өөр өөр цаг үеийн түүхэн сэдэвт уран зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний түүх, нийгэм, соёлын онцлогийг ойлгох</p> <ul style="list-style-type: none"> • Монголын эртний уран зохиол • Орчин үеийн өгүүллэг 	<p><i>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд монголын эртний түүхэн зохиолоос уншиж, түүхэн хам сэдвийн хүрээнд эргэцүүлж, уншигчийн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо хуваалцах замаар сурагчид үндэсний түүхээ гүн гүнзгий танин мэдэх эрмэлзэл, үзэл хандлагатай болно.</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Сурагчид эртний түүхэн зохиолоос танхимд хэсэглэн уншина. (Том хэмжээний зохиолыг гэрийн даалгавраар урьдчилан уншсан байна) 2. Зохиолд үзүүлсэн түүхэн хэрэг явдал, түүхт хүний дүрийн талаар ярилцана. 3. Зохиолд үзүүлсэн хэрэг явдал таны сэтгэлийг хэрхэн хөдөлгөж, түүхийн ямар мэдлэгтэй хэрхэн холбогдож, юуг бодогдуулсан талаар тусган эргэцүүлнэ. 4. Тус түүхэн хэрэг явдлыг үзүүлсэн орчин үеийн ямар зохиол байдаг талаар ярилцаж, орчин үеийн богино өгүүллэгээс уншина. 5. Тус зохиолд ямар түүхэн дүрүүдийг хэрхэн үзүүлж байгааг ярилцана. 6. Мөн зохиолыг уншаад төрсөн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо нөхөдтэйгөө хуваалцана. 	<p>Судлах эх зохиол</p> <ol style="list-style-type: none"> 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Намсрай “Жамухын өчил” 3. Ж.Саруулбуян “Бодончар богд” өгүүллэг <p>Монголын нууц товчоо. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн</p>

	<p>7. Судалсан зохиолуудад хам сэдвийн хүрээнд түүхэн хэрэг явдал хийгээд түүхэн хүний дүрийг хэрхэн ялгаатай илэрхийлсэн талаар харьцуулан ярилцана.</p> <p><i>“Монголын нууц товчоо” зохиолыг гол хэрэглэгдэхүүнээ болгон эхэлж уншаад, энэ зохиол нь хам сэдвийн хувьд монголын түүхийн аль цаг үетэй холбогдож, ямар түүхийг сануулж байгаа талаар ярилцаж, аль болох олон сурагчийн сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлыг сонсож хуваалцана.</i></p>	<p><i>Дамдинсүрэн орчуулав)</i></p>
<p>10.1а Өөр өөр цаг үеийн яруу найргийн зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусгэн эргэцүүлэх замаар үндэсний түүх, нийгэм, соёлын онцлогийг ойлгох</p> <ul style="list-style-type: none"> • Монголын эртний яруу найраг • Орчин үеийн шүлэг 	<p><i>Монголын эртний яруу найргийн зохиолоос уншиж, соёлын хам сэдвийн хүрээнд эргэцүүлэн, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо хуваалцах замаар сурагчид үндэсний соёлоо илүү гүн гүнзгий танин мэдэх эрмэлзэл, үзэл хандлагатай болно.</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Сурагчид шүлгийг бүрэн эхээр уншина. 2. Сурагчид уянгын баатрын мэдрэхүйд өртөх өнгө, гэрэл, дуу анир, үнэр амтыг төсөөлөн, яруу найрагч шүлгийг бичих үедээ чухам юуг мэдэрч байсан талаар төсөөлөн ярилцана. 3. Яруу найрагт дүрслэгдсэн байгаль хийгээд ахуйн талаар эшлэл авч тайлбарлана. 4. Шүлгийг уншихад таны сэтгэлийг хэрхэн хөдөлж, ямар дурсамж, сэргээсэн болон амьдралын ямар туршлагатай холбогдож, юуг бодогдуулсан талаар тусган эргэцүүлнэ. 5. Уншсан шүлэг нь сэдвийн хувьд өөр ямар шүлэг, зохиолыг санагдуулж байгаа талаар ярилцана. 6. Судалсан шүлэгтэй сэдвийн хувьд ижил өөр нэгэн шүлгийг уншиж, мөн адил тусган эргэцүүлж, сэтгэгдлээ хуваалцана. 7. Уянгын баатрын баярлан баясах, уйтгарлан гуних, эрмэлзэн тэмүүлэх, бадран зоригжих, хүсэн мөрөөдөх сэтгэлийн олон өнгө аясыг хэрхэн мэдэрсэн талаар өөрийн туршлагатай холбон сэтгэгдлээ хуваалцана. 8. Судалсан яруу найргуудад нэгэн сэдвийн хүрээнд ахуйн дүр зураг, хүмүүний сэтгэл хөдлөлийг хэрхэн ялгаатай хийгээд төсөөтэй илэрхийлсэн талаар харьцуулан ярилцана. 9. Уншсан шүлгийн хам сэдвийн хүрээнд хэлэлцэж, үндэсний соёлоо гүн гүнзгий танин мэднэ. 10. Судалсан яруу найргууд нь сэдвийн хувьд төсөөтэй ч хам сэдвийн хувьд хэрхэн ялгарч, ялгаатай далд санааг илэрхийлсэн талаар харьцуулан ярилцаж, зохиолын хам сэдвийн үүргийг үнэлж дүгнэнэ. <p>Багшид зөвлөх нь:</p> <p><i>Сонгосон шүлгүүдээс эртний яруу найргийг гол хэрэглэгдэхүүнээ болгон эхэлж уншуулаад, шүлэгт үзүүлсэн соёлын хам сэдвийн хүрээнд гүнзгийрүүлэн судлах ном, гарын авлагыг зөвлөнө.</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлэг 2. Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлэг <p>Дээрх шүлгүүдийг дараах эх сурвалжаас авч ашиглаж болно.</p> <ul style="list-style-type: none"> • Д.Равжаа “Яруу найргийн цоморлиг” УБ., 1992, 269-270-р тал • Д.Нацагдоржийн Түүвэр зохиол 1961, • Д.Нацагдорж Бүрэн зохиол УБ., 2006 • “Монголын сонгомол яруу найраг” УБ.,2005 \2007, 2011\ , 65-66, 95-97-р тал
<p>10.1а</p>	<p><i>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд монголын орчин үеийн жүжгийн зохиолоос уншиж, нийгмийн хам</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Д.Нацагдорж “Учиртай гурван

<p>Өөр өөр цаг үеийн жүжгийн зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний түүх, нийгэм, соёлын онцлогийг ойлгох</p> <ul style="list-style-type: none"> • Орчин үеийн жүжгийн зохиол • Монголын эртний жүжгийн зохиол 	<p>сэдвийн хүрээнд эргэцүүлэн, уншигчийн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо хуваалцах замаар сурагчид бие даан үзэх жүжиг, тайз дэлгэцийн бүтээлдээ сонголттой ханддаг болоход тусална.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сурагчид эхлээд орчин үеийн жүжгийн зохиолыг гол хэрэглэгдэхүүнээ болгон уншина. Боломжтой бол жүжгийн тоглолтын бичлэгээс үзнэ. 2. Тус жүжигт монголын нийгмийн хэдий үеийн амьдралыг тусгасан талаар ярилцана. 3. Зохиолыг уншихад таны сэтгэлийг хэрхэн хөдөлгөж, жүжгийн агуулга таны амьдралын ямар туршлагатай холбогдож, юуг бодогдуулсан талаар сэтгэгдлээ хуваалцана. 4. Жүжигт үзүүлсэн хэрэг явдал хийгээд нийгэм, цаг үеийг өнөөгийн нийгэм цаг үетэй харьцуулан ярилцана. 5. Жүжгийн зохиолыг уншиж, сэтгэгдлээ илэрхийлэн хариулсны дараа өмнөх ангид судалсан эртний жүжгийн зохиолоос хичээлд татан оруулж, дахин илүү бүтээлчээр сэргээн ярилцана. 6. Орчин үеийн жүжигт үзүүлсэн нийгэм цаг үе, хэрэг явдал хийгээд эртний жүжигт үзүүлсэн нийгэм, цаг үе, хэрэг явдлыг харьцуулан, адил ба ялгаатай талыг ярилцана. 7. Ийнхүү өөр өөр цаг үед бичсэн жүжгийн зохиолыг харьцуулан ярилцах замаар жүжгийн зохиолын уламжлал, шинэчлэлийн талаарх ойлголтоо нэгтгэнэ. <p><i>Багшид зөвлөх нь:</i> <i>Багшийн зүгээс зохиолд үзүүлсэн нийгмийн хам сэдэв, дэвшүүлсэн асуудлын хүрээнд сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар бусдын сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлыг хүндэтгэн сонсож, өөрийн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэхэд сургана.</i></p>	<p>толгой” жүжгийн зохиол</p> <ol style="list-style-type: none"> 2. Д.Равжаа “Саран хөхөөний намтар” жүжгийн зохиол 1. Д.Нацагдорж Бүрэн зохиол. Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойд зориулав. 1-2 боть, Хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв. ШУА., ХЗХ, УБ., 2016 2. С.Хөвсгөл. Д.Равжаагийн “Саран хөхөөний намтар” жүжгийн зохиолын шинжлэл, эх зохиол. Редактор Д.Цэрэнсодном, УБ., 2016
<p>10.16 Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлбарлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолд хүний амьдралын ямар үзэгдэл юмсын талаар хэрхэн өгүүлсэн, ямар асуудлыг хөндөж, байгаа талаар ярилцаж, зохиолын сэдвийг тодруулна. 2. Зохиолын үндсэн сэдэв, түүнийг тойрсон дэд сэдвүүдийн уялдаа холбоог тайлбарлаж, зохиолын нэр нь тухайн зохиолын сэдвийн нэгдлийг зааж чадаж буй эсэх талаар ярилцана. 3. Зохиолчийг энэхүү зохиолоо бичихэд хүргэсэн үндсэн сэдэв хийгээд зохиолчийн үзэл бодлыг холбон, зохиолын утга санааг тодорхойлно. 4. Зохиолын доторх түүх, нийгэм, соёлын хүрээний үгсээр дамжуулан зохиолын хам сэдвийг тодруулна. 5. Зохиолчийн далд санааг ойлгохын тулд сонгосон үг, өгүүлбэр нь ил буюу шууд утгыг илэрхийлж байна уу, эсвэл далд утгыг илэрхийлж байна уу гэдгийг эргэцүүлнэ 	<ul style="list-style-type: none"> ○ “Д.Равжаа “Дөрвөн улирал” шүлэг <ul style="list-style-type: none"> • Д.Нацагдорж “Дөрвөн цаг”, шүлэг 1. Буддын шашин соёлын тайлбар толь -II МУИС, УБ., 1999 он

	<p>6. Зохиолыг нухацтай уншсаны дараа энэ зохиолд юу өгүүлж байгаа болон үүнээс үүдээд уншигчид юуг бодогдуулж байгаа талаар хэдэн минут орчим бичүүлнэ.</p> <p>7. Зохиолын хам сэдэв нь зохиолын дүр, дүрслэлтэй хэрхэн холбогдож, улмаар ямар далд санааг бүтээснийг тайлан тайлбарлаж, сурагчид саналаа солилцоно. Далд санааг уран дүрслэлээр хэрхэн илэрхийлсэн талаар жишээ татан ярилцана.</p> <p>8. Уянгын зохиол уншиж байгаа бол уянгын баатрын юуг хэлэхийг хүсэж, юуг эргэцүүлж, ухааруулж байгаа, юунд итгэж найдаж байгаа талаар тайлбарлана.</p> <p>9. Хэрвээ жүжгийн зохиолыг уншиж буй бол тоглолтын санаа болоод далд утгын хоорондын холбоо хамаарлыг тайлбарлана. Сурагчид зохиолын далд утгын талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлснээр өөр өөр цаг үеийн бүтээлүүдийг уншиж, далд утгыг олон талаас эргэцүүлэн бодож сурах болно.</p>	
<p>10.1в Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц ба хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын үйл явдал хэрхэн эхэлсэн хүүрнэн өгүүлэгчийн мэдээлсэн орон цагийн тохиргоог тодруулна. 2. Зохиолын үйл явдлын гол зөрчил хийгээд зангилаа хэрэг явдлыг тодруулна 3. Зохиолын өгүүлэгдэхүүнийг зураглан, үйл явдал хэрхэн өрнөснийг тайлбарлана 4. Зохиолын зөрчил хэрхэн хурцдаж, туйлдаа хүрсэн хийгээд, зангилаа хэрхэн тайлагдсан талаар жишээгээр тайлбарлана. 5. Зохиолч хэрэг явдлыг хэрхэн дараалж, өгүүлэгдэхүүнээ яаж зохион байгуулсныг зураглан харуулна. Хэрвээ цагийг ухраах юм уу, урагшлуулсан зүйл байвал зохиомжийн онцлогийг тайлбарлана. 6. Зохиолын хүүрнэн өгүүлэгч нь хэддүгээр биеэс хэрхэн өгүүлж байгааг түлхүүр үгээр тодруулж, зохиолын утга санаа болоод хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлана. 7. Зохиолч дүрүүдийн харилцан яриагаар дамжуулж, уншигчтай хэрхэн холбоо тогтоосныг жишээгээр тайлбарлана. 	<ol style="list-style-type: none"> 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Намсрай “Жамухын өчил” 3. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг
<p>10.1г Зохиолын бодит ба хийсвэр дүр нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p><i>А. Дүрийн бодит шинж нь зохиолын санааг хэрхэн тодруулсныг тайлбарлахдаа:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Дүрийн бодит шинжийг зохиолын түүхэн нөхцөл байдал, хам сэдэвтэй холбон тодруулна. 2. Дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь түүхэн нөхцөл байдлыг тодруулна. 3. Түүхийн баримтуудыг уран сайхнаар үзүүлэхэд дүрийн бодит шинжүүд хэрхэн нөлөөлснийг ярилцана 	<ol style="list-style-type: none"> 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Намсрай “Жамухын өчил”

	<ol style="list-style-type: none"> 1. Дүрийн зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдлээс дүрийг шинжилж, дүрийг нөхцөл байдалд татан оруулж байгаа шалтгааныг тайлбарлана. Б. Дүрийн хийсвэр шинжийг тодорхойлохдоо: 2. Зөрчилт дүрийг уран сайхны талаас хэрхэн хийсвэрлэн дүрсэлснийг жишээ татан ярина. 4. Дүрийн хийсвэр шинж нь зохиолын сэдэв, утга санаанд нөлөөлснийг тайлбарлахдаа хийсвэр дүр бүтээснээрээ зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг задалж тайлбарлах 5. Хэрвээ жүжгийн зохиолоос уншиж байгаа бол энэ жүжгийн дүрүүд нь бидний танил нэгнийг санагдуулж, харилцан ярианы амьдлаг байдлаараа бидний сэтгэлийг хэрхэн татаж байгаа талаар эргэцүүлэн тайлбарлана. 6. Уянгын яруу найраг уншиж байгаа бол би баатрын сэтгэл санааны байдлаар дамжуулан яруу найргийн хүний сэтгэлийг үзүүлэх аргыг үнэлнэ. 	<ol style="list-style-type: none"> 3. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг 4. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг
<p>10.1д Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг задлан шинжлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолд үзүүлж буй орон, цагийг төсөөлөн ярилцаж, бодит орон, цаг байвал тэр талаар бичил судалгаа хийнэ. 2. Дүрийн зан төрхийг тодруулахын тулд гадаад орчин, нөхцөл байдлыг зохиолч хэрхэн дүрсэлснийг жишээ татан ярина. 3. Байгалийн зураглал нь дүрийн сэтгэл зүйг хэрхэн илэрхийлж, уншигчид хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлана. 4. Түүхэн зохиол уншиж буй бол дүрийн зорилго хийгээд хэлсэн үг, хийсэн үйлдлээс түүхэн нөхцөл байдлыг тодруулна. 5. Зохиолын дүрүүдийн хоорондын холбоо хамаарал, тэдний харилцааны дотоод орчин буюу уур амьсгалыг мэдэрч, зохиолчийн үг сонголтын үр нөлөөг үнэлнэ. 6. Зохиолын уур амьсгал нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлана 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Намсрай “Жамухын өчил” 2. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг
<p>10.1е Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалын онцлогийг тодорхойлох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Шүлгийг дуудан уншихдаа эгшиг авианы эгшиглэлийг олж сонсохыг хичээнэ. 2. Мөн гийгүүлэгч авианы давтамжийг зурж тэмдэглэн, ямар нэгэн айзам мэдрэгдэж байгаа эсэх талаар ярилцана 3. Шүлгийн дотоод хэмнэлийг олж сонссоноо жишээгээр тайлбарлана. 4. Шүлгийн холбоцыг тэмдэглэх замаар шүлгийн шадыг тодорхойлно. 5. Шүлгийн бадгууд хэрхэн бүтэж байгаа хэлбэрийн онцлогийг ажиглан тайлбарлана. 6. Шүлгийн шад, бадгууд хэрхэн зохион байгуулагдаж байгаа хэлбэрийн онцлогийг жишээгээр тайлбарлана. 7. Уянгын болон туульсын яруу найраг, жүжгийн яруу найргийн уламжлалын онцлогийг тодорхойлон дүгнэнэ. 	<ol style="list-style-type: none"> 1. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлэг 2. .Нацагдорж “Дөрвөн цаг” шүлэг 3. .Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг

<p>10.1ж. Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх</p> <ul style="list-style-type: none"> • Уянгын зохиол • Туульсын зохиол • Жүжгийн зохиол 	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолчийн үг сонголт хийгээд уран дүрийн үгийн сангийн хэрэглээг сурагчид ажиглан тэмдэглэнэ. 2. Зохиолчийн сонгон хэрэглэсэн нутгийн аялгууны үгс, харь хэлний үгс, хуучирсан үгс, мэргэжлийн үг болоод өвөрмөц үг, хэллэгийн утгыг ярилцана. 3. Зохиолч утга далдлахын тулд ямар уран дүрслэл бүтээснийг тодруулж, адилтгал болон егөөдөл, бэлгэдэл, бичил дүрслэлийн хэрэглээг шинжилж, уншигчид хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцана. 4. Зохиолч энэ зохиолдоо ямар нэгэн шинэ үг бүтээсэн эсэхийг ажиглаж, хэрвээ шинэ үг бүтээсэн бол эхийн дотор илрүүлж буй утгыг нээн тайлбарлана 5. Ахиуллын ур маяг, яруу хандал, яруу асуулт, харшууллын ур маяг, өгүүлбэрийн зэрэгцүүллийн аргаар бүтээгдсэн үг хэллэгийг таних, дүр, утга санаанд хэрхэн нөлөөлснийг дүгнэнэ 6. Бичил дүрслэл буюу нарийн ширийн зүйлсийг ажиглахдаа тэмдэг нэр болон, тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг ашигласныг анзаарч уншина. 7. Эдгээр нь уншигчийн сэтгэлийг хөдөлгөж, баяр баясал, хайр энэрэл, үзэн ядалт, гуниг, бухимдлыг төрүүлэх гэх мэтээр хэрхэн яаж нөлөөлж байгааг ярилцаж дүгнэнэ 8. Хэрвээ яруу найраг уншиж буй бол үг давталтаас эхлээд толгой, сүүл холбоцуудыг ажиглаж, уншигчийн сэтгэлд нөлөөлөхийн тулд яаж байгуулсныг шинжлэн дүгнэнэ. 	<p>Судлах эх зохиол</p> <ol style="list-style-type: none"> 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Намсрай “Жамухын өчил” 3. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлэг 4. Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлэг 5. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг 6. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг
--	---	--

БИЧИХ

Суралцахуйн зорилтууд	Сургалтын үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.2а. Уншсан зохиолын уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл, хэлний хэрэглээг задлан шинжилж, үндэслэлтэй, баримт нотолгоотой үнэлж, дүгнэн бичих</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг онцолж, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглана. 2. Зохиолоос хуучирсан үг, шинэ үг, нутгийн аялгууны үг, харь хэлний үгс гэх мэт уран дүрийн үгсийн сангаас оновчтой сонгож хэрэглэсэн үгсийг түүж бичээд, зохиолын утга хийгээд дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг жишээгээр тайлбарлана. 3. Зохиолоос адилтгал, хэтрүүлэл, егөөдөл, ёгтлол, бэлгэдэл зэрэг уран дүрслэлийн болоод бичил дүрслэлийн хэрэглээг тодруулж, зохиолын утга хийгээд дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг үндэслэлтэй жишээ баримтаар тайлбарлана. 4. Зохиолоос яруу асуулт, яруу хандал, зэрэг яруу хэрэглүүрийн жишээг бүртгэж, үндэслэлтэй тайлбарлан бичнэ. 5. Хэрвээ уянгын зохиолын хэл найруулгыг шинжилж буй бол уншигчийн сэтгэл хөдлөлийг дагуулахын тулд шүлэгт ямар дүрслэх ба яруу хэрэглүүрийг ашиглаж, хэрхэн уран дүрсэлсэн талаар задлан шинжилж бичнэ. 6. Зохиолд дэвшүүлсэн асуудал хийгээд сэдэв утгыг тодруулахад хэлний хэрэглээ хийгээд найруулгын сонголт хэрхэн нөлөөлсөн талаар нэгтгэн дүгнэнэ. 	<p>Сонгож шинжлэх эх зохиол:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Равжаа “Дөрвөн улирал” шүлэг 3. Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлэг, “Ламбугайн нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг

<p>10.26 Уншсан зохиолоос сэдэвлэн, хувирган зохиож, богино өгүүллэг туршин бичих</p>	<ol style="list-style-type: none"> 1. Уншсан зохиолын сэдвийн хүрээнд тодорхой асуудал дэвшүүлж, зохиолын сэдвийг сонгоно. 2. Сонгосон сэдвийн хүрээнд ямар хэрэг явдлыг үзүүлэхээ төлөвлөн, өгүүлэгдэхүүний зураглал гаргана. 3. Өгүүлэгдэхүүний зураглалын дагуу үйл явдлыг эхлүүлэн бичихдээ хэрэг явдлыг үзүүлэх орон ба цагийн тохиргоог хийнэ. 4. Өгүүллэгийн орон, цагийг тохируулахдаа орчны буюу байгалийн зураглалыг бүтээнэ. 5. Сонгосон хэрэг явдлын зөрчлийг бүтээхдээ ямар гол ба туслах дүр, сөрөг дүрийг бүтээхээ төлөвлөн, төлөвлөгөөний дагуу зохион бичнэ. 6. Зохиолын дүрүүдийг дүрслэн үзүүлэхдээ уншигчид нөлөөлөхийн тулд уран дүрслэл, адилтгалын аргыг туршин хэрэглэнэ. 7. Зохиолын өгүүлэгдэхүүний зураглалын дагуу үйл явдлыг өрнүүлэн бичихдээ зохиолынхоо дүрийг илүү амьдлаг болгохын тулд уран дүрийн сангаас тохирох үгсийг сонгон хэрэглэнэ. 8. Зохиолын утгыг тодруулахын тулд хүүрнэлийн хэлийн боловсронгуй болгож, адилтгал, хэтрүүлэл, егөөдөл, ёгтлол, бэлгэдэл зэрэг уран дүрслэлийн болоод бичил дүрслэл, яруу хэрэглүүрийг оновчтой хэрэглэсэн эсэхээ шалгана. 9. Зохиолын өгүүлэгдэхүүний зураглалын дагуу үйл явдлыг төгсгөхийн тулд хэрэг явдлын туйл болоод тайллыг үнэмшилтэй, сонирхолтой хийж чадсан эсэхээ шалгана. 10. Зохиолыг төгсгөхийн тулд хэрэг явдлын тайлал, уншигчийн санаанд оромгүй эргэлтийг үзүүлж чадсан эсэхээ шалгана. 11. Зохиолын хэл найруулга оновчтой болсон эсэхийг дахин хянаж сайжруулна. 12. Зохиолд дэвшүүлсэн асуудал хийгээд сэдэв утгыг бүрдүүлэхийн тулд сонгосон дүр, орчин, хэрэг явдал, хэл найруулга оновчтой болсон эсэхийг бусдад уншуулж, туршина. 13. Зохиосон өгүүллэгээ бүтээлийн сандаа хийж, багшдаа шалгуулна. 	<p>Сэдэвлэх эх зохиол: 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав)</p>

ЯРИХ-СОНСОХ

Суралцахуйн зорилтууд	Сургалтын үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.3а. Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэн харилцах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын дүр, дүрслэлтэй холбогдон илэрсэн мэдрэмжээ хуваалцана 2. Зохиолд үзүүлсэн түүхэн цаг үетэй холбогдон сэтгэгдлээ хуваалцана 3. Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо хуваалцана. 4. Зохиолыг уншаад, түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо нөхөдтэйгөө хуваалцан хэлэлцэнэ. 5. Жүжгийн тоглолтын хувьд дүрийн амьдлаг хэл яриагаараа бидний сэтгэлийг хэрхэн хөдөлгөж, хэрхэн дагуулж, байгаа талаар мэдрэмж сэтгэгдлээ хуваалцан илтгэнэ. 	<p>Сонгох эх эх зохиол: 1. “Монголын нууц товчоо” (Хуучин монгол хэлээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав) 2. Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлэг</p>

	<p>6. Яруу найргийн хувьд уянгын баатрын сэтгэл хөдлөл болоод үзэл бодлыг өөрийн сэтгэлийн олон янз байдал, үзэл бодолтой харьцуулан, ямар адил ба ялгаатай чанартай байсан тухайд хэлэлцэнэ.</p>	<p>3. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс өгүүллэг 4. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг</p>
--	---	---

Х АНГИ: УРАН ЗОХИОЛ (СОНГОН СУДЛАХ)

Монголын уянга, туульс, жүжгийн яруу найргийг уншиж, судлах

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.1а. Монголын уянга, туульс, жүжгийн яруу найраг, сэтгэл зүйн өгүүллэгийг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, далд санааг тайлан тайлбарлах</p>	<p>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид монголын сургаалын яруу найраг, туульсын яруу найраг, жүжгийн яруу найраг, уянгын яруу найргийн уламжлалын танил хэлбэрүүдээс сэргээн уншиж, харьцуулан судлах замаар яруу найргийн төрөл хэлбэрийн талаарх мэдлэг хийгээд яруу найргийг зүйлчлэн ангилах талаар ойлголттой болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол баатарлаг туульсын бичвэрийг тууль хайлах эх бичлэгтэй нь харьцуулан сонсож, шууд амаар аялгуулан хэлж бүтээх чөлөөт хэмнэлийг мэдрэх, туульсын бүтэц, хэл найруулгыг судалж, баатрын гавъяат үйлсийг алдаршуулан магтах сэтгэлгээг тайлбарлах замаар туульсын яруу найргийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ. 2. Монголын сургаалын яруу найргийн баялаг уламжлалаас сонгон уншиж, хүн зоны зан суртхуунд шүүмжлэлтэй хандсан, голдуу заан сургах, ертөнцийг танин мэдүүлэх, үндэстний оршихуйн үнэт зүйлсээ уламжлан дамжуулах зорилгыг тайлбарлах замаар сургаалын яруу найргийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ. 3. Ардын харилцаа дууны болоод хуримын зан үйлийн жүжиг наадмын яруу найргийн харилцаа шүлгийн шалггаацлыг задлан шинжлэх замаар жүжгийн яруу найргийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ. 4. Хүний сэтгэл хийгээд сэрэл мэдрэмжийн илэрхийлэл болсон уянгын яруу найргуудыг уншиж, баярлан баясах, уйтгарлан гуних, эрмэлзэн тэмүүлэх, бадран зоригжих, хүсэн мөрөөдөх сэтгэлийн олон өнгө аясыг мэдрэх, уянгын яруу найргийн хүний сэтгэлийг дүрслэх, сэтгэлд нөлөөлөх зорилгыг тайлбарлах замаар уянгын яруу найргийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ. 5. Байгалийн уянга, сэтгэлийн уянга, иргэний уянгын яруу найргийн нэг нэг шилдэг жишээг харьцуулан уншиж, тайлбарлах замаар уянгын яруу найргийг зүйлчлэн ангилах туршилт хийнэ. 	<p>Ч.Жачин нар. Уран зохиол IV. УБ-ын 12 жилийн сургуулийн 10 дугаар ангид үзнэ. УБ., 2012 Судлах зохиолууд Жангар. Халимаг хэлээс буулгасан Т.Дүгэрсүрэн УБ., 1963 Лувсанданзан “Алтан товч”-ийн сургаалын шүлгүүдээс Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” эмгэнэлт дуурийн харилцаа шүлгээс Б.Явуухулан. “Мөнгөн хазаарын чимээ” , “Туулын шугуй”, “Би хаана төрөө вэ?” В.Инжаннаши. Сэрүүн намар Д.Равжаа “Үлэмжийн чанар” Ц.Гайтав “Ялалт” Д.Цэдэв “Сэвтэв нь үгүй сэтгэл” , П.Бадарч “Эхийн сэтгэл” гэх мэт сурах бичгийн 8-42 тал</p>

Багшид зөвлөх нь:

Уран зохиолын заавал судлах агуулгаар сурагчид уянгын яруу найргийг түлхүү судалсан тул энэ түвшинд шүлэглэсэн хэлбэрээр бүтээгдсэн уянга, туульс, жүжгийн зохиолын бүхий л хэлбэрийг уншиж харьцуулан, адил ба ялгаатай талыг танин мэдэхэд анхаарна. Сурагчдын монголын уянга, туульс, жүжгийн яруу найргийн уламжлалын талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэхийн тулд өмнө судалсан танил зохиолуудаас хэсэглэн уншуулж, сэргээн сануулах замаар яруу найргийн төрөл хэлбэрийн онцлогийг харьцуулах тал дээр түлхүү анхаарахыг зөвлөж байна. Чингэхдээ яруу найргийн төрөл хэлбэрийн ялгаатай онцлогийг сурагчдаар бие даан тодорхойлуулж, ангиллыг өөрсдөөр нь хийлгэж, мэдлэг бүтээлгэх чухал

<p>10.1в. Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалын онцлогийг задлан шинжилж, тайлбарлах</p>	<p>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид яруу найргийн айзам, эгшиглэл болоод бадаглалын талаарх мэдлэг ойлголттой болно.</p> <ol style="list-style-type: none">1. Шүлгээс ямар айзам хэмнэл мэдрэгдэж байгаа, энэ нь уншигчид хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцана.2. Шүлгийн толгой, сүүл, бие холбоцыг загварчлан үзүүлж, нүдэнд харагдах ба сонорт сонсогдох холбоцыг ялгах, харьцуулах3. Шүлэгт гийгүүлэгч ба эгшиг авианы зохицлоор хэрхэн дүр бүтээж, уншигчид нөлөөлж байгааг тайлбарлах4. Шүлэг хэдэн шадаар бадагласныг ажиглах5. Шүлгийн шад дахь үг ба үеийн тоо тэнцүү байгаа эсэхийг загварчлан үзүүлэх	<p>Нэмэлт эх сурвалж, ашиглах материал: МУЗ-ын дээжис. 1-р боть, УБ 1995 Бэгзийн Явуухулан. Түүвэр зохиол. УБ., 1985 Монголын сонгомол яруу найраг. Г.Аюурзана нар. УБ., 2005 Энхбаяр С. <i>Утга зохиолын онол</i>. Нэмэн засварласан 3 дахь хэвлэл. УБ., 2011 Д.Галбаатар Уран зохиол. Нэвтэрхий толь. УБ 2012 Г.Нандинбилиг <i>Яруу найргийг задлан шинжилж, заан сургах нь</i>. УБ., 2011</p>
---	--	---

Багшид зөвлөх нь

Яруу найраг бол эх хэлний эгшиглэл хийгээд айзамт чанарыг тодотгон хөгжүүлж байдаг урлаг. Зарим шүлэгт тодорхой үг хэллэгийг давтаж, санаагаа баталдаг бол зарим шүлэгт холбоцыг өргөнөөр хэрэглэж, эгшиг ба гийгүүлэгч авианы сонсогдох нөлөөгөөр хэмнэл үүсгэхийг чухалчилсан байдаг.

- ✓ **Айзам зүй.** Айзам зүй нь тухайн хэлний хууль зүйгээр нөхцөлдөн сонгодог яруу найргийн амьд туршлага дээр үндэслэн бүтсэн шүлгийн айзамт байгууллын зүй тогтол, дотоод хэмнэлийг судалдаг.
- ✓ **Эгшиглэл зүй** . Эгшиглэл зүй нь шүлгийн авианы байгууллын бүтэц, хуулийг судална.
- ✓ **Бадаглал зүй** . Бадаглал зүй нь айзам аялгын нэг бүхэл бүтэн зохиомж болсон бадаг хэрхэн нэгдэж бүтдэг хэлбэр онцлогийг судалдаг.

<p>10.2а Уншсан зохиолтой холбогдох судлал шүүмжлэлийн</p>	<p>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид сурагчид судалсан зохиолоос нэгийг сонгон, холбогдох судалгааны бүтээлийн ном зүйг бэлтгэх, судалгааны байдлыг тоймлон танилцуулах замаар тодорхой уран бүтээл, түүний шүүмж судалгааны ач холбогдлын талаар ойлголттой болно.</p> <ol style="list-style-type: none">1. Судалсан зохиолоос нэгийг сонгох2. Холбогдох нэг судалгааг уншиж, түүний ном зүйгээс мэдээлэл авах3. Холбогдох судалгааны бүтээлийн ном зүйг бэлтгэх	<p>Сонгох зохиолууд: Д.Равжаа “Дөрвөн улирал” Д.Нацагдорж “Дөрвөн цаг” Д.Нямсүрэн “Дөрвөн цаг” Б.Явуухулан. “Мөнгөн</p>
---	---	---

<p>бүтээлийн талаар тойм өгүүлэл бичих</p>	<p>4. Тус зохиолын судлагдсан байдлыг он дарааллын дагуу тоочин танилцуулж, тоймлон бичих</p> <p>5. Бичвэртээ эшлэл, зүүлт хийх</p>	<p>хазаарын чимээ” , “Туулын шугуй”, “Би хаана төрөө вэ?” В.Инжаннаши. Сэрүүн намар Нэмэлт эх сурвалж, ашиглах материал: Монголын уран зохиол судлалын шинэ хандлага. БСШУЯ, ШУАХЗХ, УБ 2008</p>
<p>Багшид зөвлөх. Ажлын хуудас бэлтгэх.</p> <p>1. Судалсан шүлгүүдэд адил ба ялгаатай ямар шинж чанарууд байсан тухайд харилцан ярилцах замаар монголын яруу найргийн хөгжил, уламжлал шинэчлэлийн талаар төсөөлөл, ойлголттой болоход нь туслах</p> <p>2. Тойм судалгаанд зориулж ажлын хуудас бэлтгэх . Сонгосон бүтээлийн талаар х хамгийн үр дүнтэй нэг судалгааг түлхүүр болгон зөвлөх</p> <p>3. Сурагчдад туслах үүднээс зарим тойм су далгааны материалыг бэлтгэсэн байх.</p> <p>Сурагчдаас заавал бүрэн хэмжээний тойм судалгааг шаардаж хүндрүүлэх хэрэггүй юм. Хамгийн гол нь тодорхой уран бүтээлийн судалгааны талаар анхны ойлголттой болж, ном зүйн бүртгэлээ он дарааллын дагуу тойм лон танилцуулж сурах, судалгааны бичвэрийн хэл найруулгын онцлогийг танин мэдэхэд хангалттай.</p> <p>Бие даан судлах цагийн мтодорхой хэсгийг сурагчдаар яруу найргийн тойм судалгаа уншуулж, судалгааны хэл найруулгад суралцуулж эхлүүлэхэд чиглүүлэхийг зөвлөж байна</p>		
<p>10.26 Уран дүрслэл, яруу хэрэглүүр ашиглан шүлэглэн зохиох</p>	<p>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид уран дүрслэл, яруу хэрэглүүр ашиглан, тодорхой сэдвийн хүрээнд шүлэглэн зохиож бичих чадвараа хөгжүүлнэ.</p> <p>1. Монгол баатарлаг туульсын шүлэглэлийн туршлагаас суралцаж, тоочин дүрсэлж шүлэглэхдээ уншигчдаа татахын тулд уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ашиглан турших</p> <p>2. Жүжиг наадмын харилцаа шүлгийн шалгаацлаас суралцан , шүлэглэн зохиохдоо уншигчдаа нөлөөлөхийн тулд уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ашиглан турших</p> <p>3. Уянгын яруу найрагт хүний сэтгэлийн олон өнгө аясыг үзүүлэх бодгаль яруу найрагчийн туршлагаас суралцан, уншигчдаа нөлөөлөхийн тулд уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ашиглан турших</p>	<p>Жангар. Халимаг хэлээс буулгасан Т.Дүгэрсүрэн УБ., 1963</p> <p>Лувсанданзан “Алтан товч”-ийн сургаалын шүлгүүдээс Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” эмгэнэлт дуурийн харилцаа шүлгээс Б.Явуухулан. “Мөнгөн хазаарын чимээ” , “Туулын шугуй”, “Би хаана төрөө вэ?” В.Инжаннаши. Сэрүүн намар Д.Равжаа “Үлэмжийн чанар”</p>
<p>Багшид зөвлөх. Уншиж судалсан яруу найргийн шад, бадаг, холбоцоос суралцан зохиоход туслах загвар үзүүлэн бэлтгэх</p>		

Монголын сэтгэлзүйн өгүүллэг, туужийг уншиж судлах

Унших

Хүрэх үр дүн: Монголын сэтгэлзүйн өгүүллэг, туужийг уншиж, бүрэлдэхүүн хэсгийн задлал хийх явцдаа сурагчид дараах чадвар эзэмшинэ.

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.1a Монголын сэтгэл зүйн өгүүллэг, туужийг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, далд санааг тайлан тайлбарлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Эх зохиолуудыг анхааралтай, дүрийн өсөлт хөгжилтийн дагуу унших. Зохиолын дүр анх зохиолд яаж дүрслэгдээд зохиолын өрнөлийн дагуу хэрхэн өөрчлөгдөн хувьсаж ямар төлөвшлийг олж төгсөж байгааг олж тогтоох 2. Зохиолын дүрүүд өөрчлөгдөн төлөвшихөд тэдний үзэл бодол, үйл хэрэг хэрхэн нөлөөлж байгааг анхаарах. Дүрүүдийн ямар шийдлүүд ямар үр дагаварт хүрч байгааг олж тогтоох. Улмаар сайн сайхан үр дагавартай үзэл бодол, үйл хэргийн учир шалтгаан юу юу болохыг олж жагсаах 3. Дүрийн төлөвшил, өсөлт хөгжилтөд үзэл бодол, үйл хэрэг нь нөлөөлөх энэ зүй тогтолтой уялдуулан хүний аж амьдралд өөрийнх нь сэтгэл зүй, үйл хэрэг шууд нөлөөлдөг болохыг зөв ухаарах. Өөрөөр хэлбэл хүн бол сэтгэлийн амьтан болохыг таньж мэдэх 4. Сэтгэл байвал зүтгэл бий болдог, зүтгэл байвал амьдрал бий болдог ертөнцийн жам зүйг зохиолын дүрүүдийн сэтгэл зүйн өөрчлөлт, үйл хэргээс олж тогтоох 5. Дүрийн сэтгэл зүйн өөрчлөлт, үйл хэргээр зохиол бүхэлдээ өрнөдөг болохыг ойлгож, зохиолд гарах бүх үйл хэрэг, дүрслэлүүд бүгд дүрүүдийн сэтгэл зүй буюу үзэл бодол, үйл хэрэгтэй холбогдож байгааг олж учрыг тайлбарлах 6. Зохиолын дүрүүдийн үзэл бодол, үйл хэргийг бие биенийх нь уялдаа холбоонд авч үзээд, зохиолд тэднээр дамжуулан ямар утга санааг хэрхэн урласныг олох. Ингэхдээ туслах дүрүүдийн үзэл бодол, үйл хэрэг гол дүрдээ хэрхэн үйлчилж байгаа шугмаар нь хөөж олох хэрэгтэй. 	<p>Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” тууж Д.Маам “Өндөр Сүхээ гуай” өгүүллэг</p>
<p>Багшид зөвлөх нь:</p> <p>Эх хэрэглэгдэхүүн болгож сонгож авсан Д.Маамын “Өндөр Сүхээ гуай” өгүүллэг, Д.Батбаярын “Цахилж яваа гөрөөс” туужийг тодорхой хугацааны өмнө хүүхдүүдээр унших даалгавар болгож өгөөрэй. Мэдээж тус тусад нь цувуулан уншуулж хичээл хийх хэрэгтэй. Нэг зохиолыг 7 орчим хоногийн хугацаатай өгвөл зохимжтой байж магадгүй. Учир нь хэт цөөн хоног өгвөл хүүхдүүд уншиж амжихгүй, уншлаа ч сайн бодож уншихгүй, хэт олон хоног өгвөл уншаад бодсон нарийн чухал зүйлүүдээ мартаж болох талтай.</p> <p>Эх зохиолуудыг унших даалгавар өгөхдөө багш тусгай асуултууд бэлдэж өрөөрэй. Өөрөөр хэлбэл сурагчид багшийн өгсөн асуултанд хариулах маягаар унших. Бас асуултыг няцааж, шинэ сонирхолтой санааг олохоор асуултууд байж болно. Асуултуудыг багш бүр өөр өөрийн заах арга, орчин нөхцөлдөө тааруулан зохиогоорой. Үлгэр болгож доор цөөн асуултыг оруулъя. Д.Маам “Өндөр Сүхээ гуай” өгүүллэгийг унших даалгавар өгөх үед:</p> <p>Зохиолын нэрийг зохиолч яагаад “Өндөр Сүхээ гуай” гэсэн бэ? Сүхээ гуай өндөр хүн мөн үү? Үзэл бодол, үйл амьдрал нь хэр өндөр байна вэ?</p>		

- ✓ “Өндөх Сүхээ гуай” өгүүллэгийг уншаад хүний амьдралд юу хамгийн чухал, юу юу дараагаар нь чухал болохыг олж үзэв?
 - ✓ Энэ өгүүллэгийг уншаад хүнд эрдэм ном сурахын ач тусыг хэрхэн ухаарав? Сүхээ ямар зүйл сурсны үр дүнд амьд үлдэж, азтай сайхан амьдарч байна вэ?
 - ✓ Сүхээ гуайг юу хөдөлмөрч, шударга болгосон бэ?
 - ✓ Хүний сэтгэл гэдэг ямар их хүчтэй, чадалтай зүйл болохыг зохиолд хэрхэн урласан байна вэ? Өөрийнхөө сэтгэлийн тэнхээ, хатын тухай юу гэж эргэцүүлэв?
 - ✓ Хүний сэтгэл гэдэг ямар их нүгэл хилэнц, жаргал цэнгэлийг шингээж болдог болохыг зохиолд хэрхэн урласан байна вэ?
 - ✓ Зохиолд гарах Эрдэнэ-Ус нэгдлийн туслах бригадын дарга зохиолын эхэнд юу бодож байв? Сүхээ гуайн яриаг сонсоод хэрхэн үзэл бодол нь өөрчлөгдөж байна. Үзэл бодлоо өөрчилснөө хэрхэн илэрхийлэв? Энэ илэрхийлэл хэр зохимжтой илэрхийлэл гэж та нар бодож байна вэ? Та нар бригадын даргын оронд байсан бол Сүхээ гуайн яриаг сонсоод яах байсан бэ?
- Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” туужийг унших даалгавар өгөх үед:
- ✓ Дэжид нөхрийнхөө муу үйл хэргийг мэдсэн ч нөхрөө хөөх тухай огт бодоогүй байсан хэрнээ яагаад гэнэт хөөсөн бэ?
 - ✓ Дамба эхнэрээсээ салах тухай хэзээ ч бодож байгаагүй хэрнээ яагаад гэнэт эрс шийдэлд хүрэв? Энэ юунаас болсон гэж бодож байна вэ?
 - ✓ Дамба Дэжид хоёр хоёулаа огт бодож байгаагүй шийдвэрийг гэнэт гаргасан. Энэ юунаас болов? Энэ гэнэтийн шийдвэр хэнд аз болж? Хэнд эз болов? Яагаад?
 - ✓ Дамбыг гэрээсээ явахад хүү нь богцтой хувцсыг нь дөхүүлж өгч байна. Зохиолын энэ хэсгийг “Гарын таван хуруу” кинотой харьцуулан авч үзээрэй. Тэгээд ямар сэтгэгдэл төрж байгаагаа өөр өөрийнхөөрөө тайлбарлаарай.
 - ✓ Дамбын хүү аавдаа хамгийн хайртай, эрхэлж өссөн, аавыгаа хамгаас илүү санадаг ч зохиолын төгсгөлд аавынхаа шинэ гэрт очоод буцахын түүс болж байдаг. Яагаад тэгсэн бол?
 - ✓ Зохиолын төгсгөлд зохиолч Дэжид хүүгийн хамт Дамбынд очиж, өвөг дээдсээс нь уламжилж ирсэн хүрэл гөрөөсийг хүргэж өгчхөөд явахад хийе гэснээ хийсэн мэт сэтгэл нь юу ч үгүй болж, юуг ч бодох хүсэлгүй болж байгаа тухай бичдэг. Дэжидийн хувьд ийм байх боломжтой юу?
 - ✓ “Цахилж яваа гөрөөс” гэсэн зохиолын нэрийг дүрүүдийн сэтгэл зүйн онцлог, үйл амьдралтай нь холбож тайлбарлаарай гэх мэт
Зохиолуудыг хичээл тус бүр дээр өгсөн асуултуудын дагуу ярилцах. Ингэхдээ багш бүр урьдчилан өгсөн асуултуудынхаа уялдаа холбоог бодож, ярилцах дэс дарааг зөв тогтоох. Хүүхдүүдийн ярьсан яриаг аль бодох дэмжиж, зохиолын дүрүүдийн дотоод мөн чанар руу гүн оруулахыг хичээх. Хүүхдийн бэлдэж ирсэн зүйлүүдээр дамжуулан сайныг дэмжин дэлгэрүүлэх, саарыг жигшин буруутгаж амьдралдаа мөрдлөг болгох арга зам руу хөтлөхийг хичээгээрэй.
- Дөрөв: Багш өөрийн санаа бодлыг хүүхдүүдийн ойлгож ухаарсан ухаарлыг дэмжих, залруулах зорилгоор хичээлээ гүнзгийрүүлэн лавшруулж заахдаа судлаачдын судалгаа шинжилгээний үр дүнг жишээ баримт болгож ашиглах.
- “Өндөр Сүхээ гуай” өгүүллэгийг заасны эцэст “Хөдөлмөр хүнийг хүн болгодог” гэсэн үгний учрыг, “Цахилж яваа гөрөөс” туужийг заасны дараа “Хорвоод эцэг эх байхын утга учир. Үүрэг хариуцлага юу байх” тухай ярилцлага өрнүүлж болох юм.

<p>10.16 Дүрийн зан төрх ба сэтгэл зүйн шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>Дүрийн зан төрхийг тодорхойлох:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн дүрийн сэтгэл, оюунд бүрэлдсэн авир араншингийн давтагдашгүй шинж буюу зан ааш, бодол санаа, сэтгэлийн ертөнцийг илэрхийлсэн хэсгүүдийг зохиолоос олж, харьцуулан тайлбарлах 2. Ааш авир, бодол сэтгэлийн далд ертөнцийн гадаад илэрхийлэл буюу намба төрх, үйлдэл, хэл ярианы илэрхийллийг зохиолч хэрхэн дүрсэлснийг олж, үүгээр юу хэлэхийг зорьсон болохыг тайлбарлах 3. Давтагдашгүй амьдралын өвөрмөц орчин ахуй, бүрэлдсэн нөхцөл байдал зэргийг олж, сэдэв утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах <p>Дүрийн сэтгэл зүйн шинжийг тодорхойлох:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дүрийн сэтгэл зүйн олон илрэл, хувирал өөрчлөлт, шалтгааныг тайлбарлах 2. Дүрийн сэтгэлийн олон өнгө аясыг уянгалаг, дахин давтагдашгүй өвөрмөц байдлаар ургуулан бодож, дүрийн сэтгэлийн нарийн нандин рүү өнгийн харж, зохих газарт нь хэрхэн шигтгэн дүрсэлснийг тайлбарлах 	<p>Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” Д.Маам “Өндөр Сүхээ гуай”</p>
---	---	---

	<p>3. Зохиолын хэрэг явдлын хооронд зайлшгүй сэрэхийг шаардсан хэрнээ үгээр бэлэн зэлэн илэрхийлчих боломжгүй, сэтгэл санаа гижигдсэн, зайлшгүй нэмэлт тайлбар шаардсан тэр торгон мөч, хэсгүүдийг шингээсэн байгааг олж тайлбарлах гэх мэт</p> <p>Дүрийн зан төрх, сэтгэлзүйн дээрх шинжүүд нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	
--	---	--

Багшид зөвлөх нь:

Хүн бүр өөр өөр байдгийн хамгийн гол зүйл нь үзэл бодол, санаа сэтгэлдээ байдаг жамтайг хүүхдүүдэд юуны өмнө зөв ойлгох

Хүний зан ааш, авир араншин зохиолын дүрд хэрхэн илэрдгийг жишээ баримтад тулгуурлан тайлбарлах. Дүрийн зан ааш, сэтгэл зүйн өсөлт хөгжилт гадаад дүрслэл, үйл хэрэгтэйгээ хэрхэн уялдаж байгааг хүүхдүүдээр гаргуулахын тулд багш тэдэнд ойр дөхөм болох асуултууд бэлтгэж хичээлдээ ашиглавал зүгээр байх

Уншсан зохиолуудын үйл явдлын өрнөлүүд гарах хэсгүүд нь дахин давтагдашгүй онцлогтой болохыг тайлбарлах. Уг асуудлыг ойлгуулахад баталгаа болгож өөр өөрийн заах арга, туршлага, нөхцөл байдалтайгаа холбож бэлтгэл хийгээрэй.

Дүрийн сэтгэл зүйн шинж хэрхэн өрнөж, үйл хэрэг болон хувирч байгааг жишээ баримтад тулгуурлан тайлбарлаарай. Тухайлбал, Дүрүүдийн сэтгэлзүйн байдлыг илэрхийлэхдээ эд юмсад хандаж байгаа хандлагаар дүрийн дотоод бодол илэрч байгаагаар тодотгожээ. Тухайлбал: “гал”-тай холбож, Дамба эхний удаа Дэжидийн үгийг сонсоод гайхсан байдлыг “дэмий л гаансаа амандаа зуун, асаагаагүй тамхи хий сорж эхлэв” гээд, “авъя л гэснээ аваарай” гэснийг сонсоод “шүдэнз гарган шархийтэл хавирч тамхи асаангаа” гэсэн өгүүлбэрээс “хий сорох”, “шархийтэл” хавирах” үйл хөдлөлүүд нь дүрийн дотоод сэтгэлзүйг гадаад хандлагаар илэрхийлснийг харуулж байна.

Мөн Дамбыг гэртээ хулган байж орж ирэхэд Дэжид данхтай цайгаа “дөхүүлж орхиод”, “том шаазан Дамбын урд тавьсан” байдлаар /угтаа айлын эхнэр эр нөхөртөө данхтай цай дөхүүлэх биш харин цайны дээжээ аягалж, хоёр гардан хүндэлж барьдаг/ дараа нь хамаг хувцсыг нь богцонд нь хийж өгсний дараа “Дамбын өмнөх данхтай цайг авч зуухан дээр тавьсан” үйл хөдлөлөөр аль хэдийн энэ айлд эр нөхрөө хүндэтгэх ёс үгүй болсныг, эр нөхөр нь аль хэдийн өөр айлын хүн болсныг дүрийн үйлдлээр төлөөлүүлж дүрсэлжээ. Энэ нь зохиолыг уран дүрслэлтэй болгожээ.

Айлын гал голомт бүтэн байхын учир утгыг илэрхийлсэн “зуух”-тай холбоотой өгүүлэмж нь зохиолын уран сайхны онцлогийг бэлгэдлийн шинжтэй болгосон байдаг. Дэжидийн “Нэгэнт л чи цаанаа хань бүлтэй болчихсон юм бол чи бид хоёр ингэж яваад яахав, эртхэн хоёр тийшээ болсон нь дээр” гэж хэлчээд “гал нь унтарсан зуухан дахь аргалын асах эсэхийг хүлээх мэт зуухны харанхуй ам руу ширтэж” байгаа энэ хэсэгт маш энгийн хэрнээ үнэн бодитой нарийн дүрслэлүүд оржээ. Тодруулбал: “гал нь унтарсан зуух” гэдгийг тэдний гэр бүлийн харьцаа холдож хөндийрснийг, “зууханд аргал”-тай гэж бичсэн нь Дэжидийн сэтгэлд нөхөр нь битгий бүүр явчхаасай гэсэн итгэлийг, тэрхүү “аргалын асах эсэхийг хүлээх мэт” гэж бичсэн нь Дэжид нөхрөөсөө “худлаа, салах сарнихыг хүсэхгүй” гэсэн утгатай үг сонсохыг хүссэн хүлээлтийг, “зуухны харанхуй ам руу ширтэв” гэснээр нөхрийнхөө сэтгэлийг холдсоныг ойлгоод цөхөрч ядаж байгаа сэтгэлзүйн зөрчилт байдлыг тус тус бэлгэджээ. “Дэжидийн эдгээр хэлсэн үгс нь гэр бүлийнхээ амьдралыг сарниулан салгая гэсэн бус, харин зуухан дахь унтран бөхөж буй галын дөлийг ахин сэргээхийн тулд өөрөөс хамаарах бүхнийг шийдмэг хийж буй хүнийг олж харна. Магадгүй зуухны ам мэт дүрслэгдэн байгаа Дамбын амнаас өчүүхэн ч гэсэн сэтгэл, итгэлийн дулаан үг гарсан аваас, энэ нь зөвхөн зууханд унтарч буй галын дөлийг сэргээгээд зогсохгүй, хүйтэрч мөсөн хонгил мэт болсон энэхүү гэр орныг бүхэлд нь дулаацуулах чадалтай байсан байж болох юм. Ингэж Д. Батбаяр гол дүрүүдийнхээ дотоод сэтгэлийн байдал, дотоод ертөнцийг чадварлаг илэрхийлж чадсан юм.”¹

Дэжидийн сэтгэлзүйг зохиолд “сүү”-тэй холбож бичсэн нь бас нэг сонин дүрслэл болсон байна. Дамбыг аймаг явах болгонд сүү өргөдөг байсан ба энэ удаа хувцастай богцоо аваад гарахад нь сүү өргөх тухай ч бодоогүй байсан аж. Хүүгийнхээ “сүү өргөөч” гэж хэлснийг биелүүлэхийн тулд л өрөмний захаас цоо татан хам хум өргөдөг байна. Улмаар хоосон шанагаа мөчид тавин унагах, шороогий нь ч арчилгүй эрэгнэг дээр тавих зэрэг үйл хөдлөлийн элементүүд, цаашлаад “өрмий нь цоолчихсон тогоотой сүү сэтгэлийг нь улам гутраан, энэ ертөнц дээр бүтэн юм ер байхгүй болсон мэт санагдаж” байгаа адилтгалын аргаар бүтээсэн дүрслэлүүдээс харахад нэг талаасаа ямар ч тайлбар шаардахгүйгээр мэдэрч унших тийм

¹ Ц.Мөнх. ред. “Утга зохиол шүүмжлэл 84”. Уб., 1986 он.172-р тал

энгийн, ончтой нь тодрох бөгөөд “хамгийн сайн зохиолыг хамгийн энгийн үгээр хэлдэг, хамгийн сайн ваарыг шавраар хийдэг” гэсэн гайхамшигт санааг нотолдог.

СОНСОХ-ЯРИХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>10.3а. Уншсан зохиолын сэдэв, хам сэдвийн хүрээнд судалгаа хийж илтгэх</p>	<p>- Хүүхдүүдээр зохиолын тухай яриулж, багш хичээл болгож нэгтгэн заагаад хүүхдүүдэд тухайн зохиолын тухай илүү их сэтгэгдэл төрүүлж, эрэл хийх урам төрүүлэхийг хичээгээрэй.</p> <p>- Хүүхдүүдийн зохиолын тухай үзэл бодлыг аль болох бусдын үзэл бодлоор баталгаажуулах, няцаалгуулахыг хичээх</p> <p>- Хүүхдүүдээр өөр өөрийнх нь үзэл бодлыг хамгаалуулахыг чухалчлаарай. Улмаар хүүхдийн үзэл бодлыг зохиолын үйл явдалтай холбож нийгмийн амьдралын бодит хөрс суурин дээр буулган яриулах.</p> <p>- Хүүхдүүдийн үзэл бодлыг баталгаажуулах, няцаалт болгох үүднээс багш мэргэжлийн судлаачдын судалгаа шинжилгээний материалаас бэлдсэн зүйлүүдээ даалгавар болгон өгч уншуулах. Улмаар хүүхдүүдээр тухайн зохиолын тухай бодож байгаа бодол санаа, судлаачдын судалгааны үр дүн, нийгмийн амьдрал зэргийг холбон уялдуулж илтгэл бэлдүүлэн илтгүүлэх, яриулах.</p>	<p>Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” Д.Маам “Өндөр Сүхээ гуай”</p>
<p>Багшид зөвлөх нь: Хүүхдүүдээр зохиолуудаа уншуулж хичээл дээр яриулан, багш дэлгэрүүлэн хичээлээ заасны дараа дүгнэлт хичээлд бэлтгүүлж уг зохиолуудыг судалсан судлаачдын судалгаатай танилцаж даалгавар өгөөд хаанаас ямар судалгаа уншиж болохыг зааж өгөөрэй. Магадгүй багш урьдчилан өөрөө доорх маягаар судалгаатай танилцаад хүүхдүүдийн унших судалгааг бэлдэж өгвөл зүйгээр байж магадгүй.</p> <ol style="list-style-type: none"> 1. Багш тухайн зохиолуудын тухай судлаачид юу гэж судалсныг аль болох олж унших. 2. Судлаачид тухайн зохиолын тухай судлаад гаргасан үр дүнг багш өөрийн үзэл бодолтой харьцуулан юуг нь авах, юуг нь үлдээхийг бодож үзээрэй. 3. Хичээлдээ баталгаа болгож авах судалгааны хэсгийг зохиолын ямар хэсгийг заах үед ашиглахыг тооцоолон бэлтгээрэй. 4. Хүүхдүүдээр уншуулах судалгааны материалыг бэлгэн өгөх 		

БИЧИХ

Суралцахуйн удирдамж	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>Уншсан зохиолтой холбогдох судлал шүүмжлэлийн бүтээлийн талаар тойм өгүүлэл бичих</p>	<p>- Уншсан зохиолуудын тухай нь төрсөн сэтгэгдлүүдийг нь тоймлон бичүүлэх</p> <p>- Уншсан зохиолуудынх нь тухай бусад судлаачид юу гэж үзсэн байгаатай танилцуулах</p> <p>- Хүүхдүүдийн уншсан зохиолынхоо тухай олж авсан үзэл баримтлал, мэдээ мэдээллийг мэдлэг болгон хэрхэн ашиглах, амьдрал ахуйдаа мөрдлөг болгох тухай багш зөвлөх</p> <p>- Хүүхэд уншсан зохиолынхоо тухай төрсөн сэтгэгдлээ бусад судлаачдын судалгаа шинжилгээний баримтуудаар баталж нотлоод нэгтгэн тоймлож бичих. Мөн зарим баримтуудыг няцаалт болгон ашиглах</p> <p>- Өөрийн бичсэн өгүүллийг дахин нягталж багцлах. Хэл найруулыг хянаж үзэх</p>	<p>Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс” Д.Маам “Өндөр Сүхээ гуай”</p>
<p>Багшид зөвлөх нь: 1. Хүүхдүүдийн уншсан зохиолынхоо тухай ярих яриаг, бодсон бодлыг нь дэмжиж өөрийн зүгээс нэмэн дэлгэрүүлж санаа өгөх.</p>		

2. Уншсан зохиолуудынхаа тухай хүүхдийн санаж бодож байгааг нийгмийн бодит аж амьдрал, ертөнцийн зүй тогтол, мөн чанартай хэрхэн холбож нэмж дэлгэрүүлж үзэх арга замыг зааж өгөх.
3. Хүүхдүүдийн уншсан зохиолын тухай судласан мэргэжлийн судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлүүдийг хаанаас олж, хэрхэн унших тухай зааж зөвлөх.
4. Хүүхдүүд өөрийн санаа бодол, үзэл баримтлалдаа мэргэжлийн судлаачдын судалгаанаас хэрхэн ашиглаж баталгаажуулан авах арга зүйг зааж зөвлөх. Ингэхдээ бусдын зохиол бүтээлээс хэрхэн авч ашиглах дүрэм журмыг зөв танилцуулах. Үүнтэй холбоотой бусдын судалгаа шинжилгээний бүтээлээс хэрхэн ишлэл авах, нэр заан ишлэл аваагүйгээс бүтээлийн хулгай хэрхэн бий болдог тухай танилцуулах. Улмаар бүтээлийн хулгай хийвэл хуулийн ямар хариуцлаг хүлээдэг болох зэргийг хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг давхар эзэмшүүлэх.